

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	15
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	22
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ
ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ
Т.МӨНХСАЙХАН ТАНАА

2020.02.21 № 06/559
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Ерөнхий захирал Т.Мөнхсайхан Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн цалин хөлсний зардал, шатахууны зардал, бараа материалтай холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 11-нээс 2020 оны 02 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Дөлгөөнхайрхан уул аудит” ХХК-ийн аудиторын туслах Д.Эрдэнэтуяа, П.Сувд-Эрдэнэ, аудитор Э.Нарангэрэл нар хариуцаж хэрэгжүүлэв.

Улсын нэгдүгээр төв эмнэлэг 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 1/190 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн зорилго, зорилт, үйл ажиллагааны талаарх товч мэдээлэл:

Улсын нэгдүгээр төв эмнэлэг нь үйлчилгээний соёл, анагаах ухааны шинэ технологи, инновацийг эрхэмлэгч, шилдэг багийн тогтолцоотой, олон улсын магадлан итгэмжлэгдсэн эмнэлэг болох эрхэм зорилготой.

Улсын хэмжээнд эмнэлгийн төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлж, анагаах ухааны сургалт, судалгаа явуулах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх эмнэлгийн байгууллагад мэргэжил, арга зүйн гурав дахь шатны лавлагаа тусламж үзүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус эмнэлэг нь төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг эмчилгээний 11 төв, 10 тасаг, дэмжих үйлчилгээний 7 алба, удирдлагын 8 алба гэсэн бүтцээр үндсэн 770, гэрээт 56, нийт 826 ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль
- Донорын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Улсын нэгдүгээр төв эмнэлэг санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Интерактив Би Ай” ХХК-ийн “Emerald” санхүүгийн программ хангамж ашигладаг байна.

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар байгууллагын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж

авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 42 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 42,243,787.0 мянган төгрөгөөс тооцон 422,437.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшин өөрчлөгдөөгүй болно.

2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 368,530.50 мянган төгрөгөөр буюу 0.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Эргэлтийн хөрөнгийн дүн	5,024,220.43	5,323,561.94	299,341.52
Мөнгөн хөрөнгө	54,100.40	34,290.12	(19,810.28)
Авлага	81,467.39	95,939.93	14,472.55
Урьдчилгаа	21,653.60	-	(21,653.60)
Бараа материал	4,866,999.04	5,193,331.89	326,332.85
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	39,283,709.33	39,352,898.32	69,188.99
Үндсэн хөрөнгө	38,426,058.44	38,488,644.67	62,586.23
Биет бус хөрөнгө	857,650.89	864,253.64	6,602.75
Нийт хөрөнгийн дүн	44,307,929.75	44,676,460.26	368,530.50
Нийт өр төлбөр	84,618.04	53,406.81	(31,211.23)
Богино хугацаат өр төлбөр	84,618.04	53,406.81	(31,211.23)
Урт хугацаат өр төлбөр	-	-	-
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	44,223,311.72	44,623,053.45	399,741.74
Засгийн газрын хувь оролцоо	21,376,629.29	21,376,629.29	-
Хуримтлагдсан үр дүн	13,438,933.99	13,831,830.23	392,896.24
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	9,407,748.43	9,414,593.93	6,845.50
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	44,307,929.75	44,676,460.26	368,530.50

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос өссөн. 94,827.2 мянган төгрөгийн авлага нь Эрүүл мэндийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 15– ны өдрийн А/512 тоот тушаалаар Өмнөговь аймгийн Ханбогд сумын иргэд, Гашуунсухайт автозамаар нүүрс тээвэрлэж буй жолооч нарт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, Сангийн яам татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгө байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 326,332.8 мянган төгрөгөөр өссөн байна. Үүнд үнэ төлбөргүй ба хандив тусламжаар авсан жижиг багаж хэрэгсэл, бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлс болон бусад хангамжийн зүйлсийн худалдан авалт нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар, хандиваар 3,004,741.7 мянган төгрөгийн хөрөнгө, эмнэлгийн барилга байгууламжид 936,633.4 мянган төгрөгийн их засвар хийж капиталжуулсан байна.

Ашиглах боломжгүй болсон 478,089.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 10 дугаар сарын 17-ний өдрийн А-1/3561 тоот албан бичиг, Эмнэлгийн Ерөнхий захирлын 2019 оны 12 дугаар сарын 26-ний өдрийн А/418 дугаар тоот тушаалаар данс бүртгэлээс хассан байна.

Мөн 15,000.0 мянган төгрөгийн программ хангамжийг худалдан авсан ба ашиглах боломжгүй болсон 293,468.0 мянган төгрөгийн программ хангамжийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 445 тоот тогтоолоор данснаас хассан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өмнөх оноос 31,211.2 мянган төгрөгөөр буюу 37.0 хувиар буурсан байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Улсын нэгдүгээр төв эмнэлэг тайлант онд 38,542,017.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 38,271,968.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж 99.3 хувьтай байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөр арга хэмжээнд зориулан 38,542,017.6 мянган төгрөгийн төсөв батлагджээ.

Нийт зардлын 12,515,218.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 21,090,476.2 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 4,936,322.8 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Тайлант онд урсгал зардлын батлагдсан төсвийн гүйцэтгэл 38,261,667.8 мянган төгрөг буюу 0.7 хувийн хэмнэлт гарсан байна. Үүнээс 30,111.0 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн.

Бараа үйлчилгээний бусад зардал 215,695.8 мянган төгрөгөөр хэмнэсэн нь өндөр өртөгт мэс заслын эмнэлгийн хэрэгслийн зардлын хэмнэлтээс үүссэн. Энэ нь 2019 онд зарласан өндөр өртөгт зарим мэс заслын нэг удаагийн хэрэгслийн тендерт Нийгмийн даатгалын ерөнхий зөвлөлөөс баталсан санхүүжигдэх үнээс илүү дүнтэй санал ирүүлснээс тендер шалгаруулалт хийгдээгүйтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв: Хандив тусламжаар Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 22,253.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 284,008.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 906,484.2 мянган төгрөг, нийт 1,212,745.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Нэмэлт санхүүжилтийн 1,071,996.8 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулж, 140,748.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. АУДИТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 23 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 12 эрсдэл тодорхойлж нийт 33 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 393,492.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 20,111.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 58,515.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 314,866.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 382,585.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 58,515.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Зардал, татвар шимтгэлтэй холбоотой асуудал

Тус эмнэлэг нь ажилчиддаа 238,960.9 мянган төгрөгийн урамшуулал олгосон ба үүнээс 27,480.5 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй ба нийт 57,350.6 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг тайлагнаагүй, төлөөгүй байна.

Мөн ёс зүйн хорооны гишүүдэд 4,852.9 мянган төгрөгийн цалин олгосон ба үүнээс 558.1 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй ба нийт 1,164.7 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг тайлагнаагүй, төлөөгүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйл. Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах дараах орлого ...-д нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна:

1/ Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан цалин хөлс, Хөдөлмөрийн тухай хууль 47.1.Цалин хөлс нь үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал урамшууллаас бүрдэнэ. гэснийг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Албан шаардлага өгөх, Аудитаар илэрсэн 314,866.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Тус эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтын гэрээ нь он дамжин үргэлжилдэг ба энэ нь тайлант онд 3,376,938.5 мянган төгрөгийн 87 гэрээ байгаа ба үүнийг өр үүсгэхгүй байх шалтгаанаар нягтлан бодох бүртгэлд аккруэл сууриар бүртгэдэггүй байна.

Мөн өндөр өртөгт мэс заслын хагалгааны төлбөрт үйлчилгээний төлөвлөгөө, гүйцэтгэлийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 143 мэдээллийг хугацаанд нь мэдээлж байршуулсан, 2 мэдээллийг байршуулаагүй байна.

2.13. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 349,202.2 мянган төгрөгийн зөрчилд 298,858.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 5 албан шаардлага хүргүүлснээс 3 албан шаардлага хэрэгжиж, 2 албан шаардлага хэрэгжээгүй ба хэрэгжилт 82 хувьтай байна.

Нийт 3 зөвлөмж өгснөөс зөвлөмжийг 80 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Цалин хөлстэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: 2019 оны 12 дугаар сард нэр бүхий 8 ажилтанд 748.5 мянган төгрөгийн цалинг илүү олгосныг ажилчдаас суутгаж аваагүй байна.

Ажилчдад олгосон хоол унааны мөнгөнд шууд албан татвар ногдуулаагүйгээс нийт 11,894.9 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татвар /ХХОАТ/-ыг ажилтнаас илүү суутгаж, татварын албанд илүү төлсөн байна.

3.2.2 Эрсдэл: Цалин илүү олгох, хөрөнгө шамшигдах.

3.2.3 Өгсөн зөвлөмж: Энэ нь үнэн зөв байдал, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцээгүйгээс гадна болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6. Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйл. Шууд бус орлогод хамруулна: 15.1.1.үнэ төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үнээр тээврийн хэрэгслээр үйлчилсэн, түүнчлэн бэлнээр олгосон унааны мөнгө; 15.1.3.бэлнээр олгосон хоолны мөнгө, түүнчлэн үзвэр үйлчилгээний олговор; 22.1.4 шууд бус орлогод ногдуулах албан татварыг тухайн орлогын дүнгээр гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: 2019 оны 12 дугаар сард нэр бүхий 8 ажилтанд 748,5 мянган төгрөгийн илүү олгосон цалинг 2020 оны 2 сарын урьдчилгаа цалингаас суутган тооцож авлага хаасан болно. Холбогдох баримтыг хавсаргав.

Цалингийн программаас 1 дүгээр сарын цалингийн тооцоололд бодолт хийж үзэхэд давхар суутгал хийгдээгүй болно. 2020.01.01 -ны холбогдох хуулийг мөрдөж ажиллана.

3.2 Балансын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт: Тайлант хугацааны эмийн орлогоос 50,000.0 мянган төгрөгөөс дээш 26 гүйлгээг түүвэрлэн шалгахад "Астелас фарма" ХХК-ийн 8 гүйлгээ нийт 1,691.1 мянган төгрөгийн Програф 0.5 мг, 1 мг эмийн баримт байхгүй, баримтын иж бүрдэл дутуу байна.

3.2.2 Эрсдэл: Бараа материалд тавих дотоод хяналт сулрах

3.2.3 Өгсөн зөвлөмж: Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай 13 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт:

13.6. Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.

13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

14 дүгээр зүйл. Нягтлан бодох бүртгэл хөтлөх

14.5. Аж ахуйн нэгж, байгууллагын аж ахуйн ажил, гүйлгээ нь аль улсын нутаг дэвсгэрт гарснаас үл хамааран холбогдох анхан шатны баримт, бүртгэлийн маягтыг энэ хуульд заасны дагуу бусад баримт, бүртгэлийн маягттай хамт хадгална. гэснийг зөрчсөн байна.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: "Астелас фарма" ХХК-тай 2019 оны В-ШГ /19/01 тоот худалдан авах гэрээний дагуу улирал тутам бараа материалыг хүлээн авч эмийн орлогот бүртгэдэг ба үүнээс 1,691,1 мянган төгрөгийн эмийг 2019.03.05 өдрийн invoice № 191566347 үндэслэж орлогод бүртгэж авсан . Хүлээж авсан баримтыг хавсаргав.

3.3 Шатахууны зардалын хэтрэлт

3.3.1 Илрүүлэлт: Шатахууны зардлыг 3 автомашинаар тулган шалгахад 1,723.6 мянган төгрөгийн шатахууныг нормаас илүү зарцуулсан нь Дэд бүтцийн сайдын 2004 оны "Жишиг норм батлах тухай" 2004 оны 19 дүгээр тушаалыг баримтлаагүй байна.

3.3.2 Эрсдэл: Шатахууныг нормоос хэтрүүлж зарцуулах, зардлыг өөр зардлын ангилалд оруулж, буруу тайлагнах

3.3.3 Өгсөн зөвлөмж: Дэд бүтцийн сайдын 2004 оны "Жишиг норм батлах тухай" 2004 оны 19 дүгээр тушаалыг баримтлах,

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Дэд бүтцийн сайдын 2004 оны "Жишиг норм батлах тухай" 2004 оны 19 дүгээр тушаалыг баримталж Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл, Техникийн комисс тээврийн хэрэгсэл ажлын байрны зураглал хийж, норм тогтоож цаашид зохих журмыг мөрдөж ажиллана.

3.4 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

3.4.1 Илрүүлэлт: Тайлант онд 9 компаний 15 гэрээний 5,431,992.8 мянган төгрөгийн гэрээний үүргийн биелэлтийг хангах 271,599.6 мянган төгрөгийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулахаас өмнө байршуулаагүй байна.

"Айвыко Интернэшнл" ХХК- ийн 14,977.6 мянган төгрөгийн, "Монгол Эм Импекс Концерн" ХХК-ийн 6,256.9 мянган төгрөгийн нийт 21,234.5 мянган төгрөгийн гүйцэтгэлийн баталгааны хүчинтэй байх хугацаа гэрээ дуусахаас өмнө дуусгавар болохоор байна.

"Жэй Эм Би" ХХК-ийн 119,486.0 мянган төгрөгийн гүйцэтгэлийн баталгаа болох 5,974.3 мянган төгрөгийг арилжааны банкинд байршуулалгүй гэрээ байгуулсан байна.

3.4.2 Эрсдэл: Хөрөнгө шамшигдах.

3.4.3 Өгсөн зөвлөмж: Энэ нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах" тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3. Гүйцэтгэлийн баталгаа нь гэрээ дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээлцэх хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байна.

43.4 "Захиалагч дор дурдсан нөхцөлд гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг гүйцэтгэгчээс шаардана. 43.4.2 "100 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй бараа, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах", гэснийг тус тус зөрчсөн байна.

3.5 **Дотоод аудит**

3.5.1 Илрүүлэлт: Дотоод аудитор нь Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралт Дотоод аудитын дүрэмд зааснаар дотоод аудитор нь 6.3.1. санхүүгийн хяналт шалгалтын тэмдэглэл болон нэг бүрчилсэн акт, танилцуулга, аудитын зөвлөмжийг хууль тогтоомж болон баримт нотолгоонд үндэслэн гаргах; гэснийг мөрдөж ажиллаагүй, өмнөх аудитаар ажлыг сайжруулах албан шаардлага өгсөн боловч хэрэгжилт хангалтгүй байна.

3.5.2 Эрсдэл: Байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны дотоод хяналт алдагдах,

3.5.3 Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралт Дотоод аудитын дүрэмд зааснаар дотоод аудитор нь 6.3.1. санхүүгийн хяналт шалгалтын тэмдэглэл болон нэг бүрчилсэн акт, танилцуулга, аудитын зөвлөмжийг хууль тогтоомж болон баримт нотолгоонд үндэслэн гаргах; гэснийг мөрдөж ажиллах, Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,024,220,428.12	5,323,561,943.66
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	54,100,400.00	34,290,120.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	54,100,400.00	34,290,120.00
3121	Төгрөг	54,100,400.00	34,290,120.00
31400	Замд яваа мөнгөн хөрөнгө	54,100,400.00	34,290,120.00
33	АВЛАГА	81,467,385.90	95,939,933.60
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,324,555.80	748,499.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	76,630,077.96	94,827,209.00
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	512,752.14	212,625.60
335	Бусад авлага	3,000,000.00	151,600.00
3351	Байгууллагаас авах авлага	3,000,000.00	151,600.00
34	УРЬДЧИЛГАА	21,653,600.00	0.00
3471	Урьдчилгаа тооцоо	21,653,600.00	0.00
34714	Томилолтын урьдчилгаа	21,653,600.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	4,866,999,042.22	5,193,331,890.06
351	Түүхий эд материал	1,680,268,882.69	1,432,448,333.59
35110	Тусгай зориулалттай материал	189,093,969.73	70,710,319.80
35130	Эм боох материал	1,491,174,912.96	1,361,738,013.79
354	Хангамжийн материал	3,186,730,159.53	3,760,883,556.47
35410	Бичиг хэргийн материал	10,075,271.44	5,379,165.00
35420	Аж ахуйн материал	4,552,600.32	1,314,267.00
35430	Сэлбэг хэрэгсэл	26,516,799.70	24,839,086.19
35440	Түлш, шатах тослох материал	4,546,999.88	5,011,997.07
35450	Барилгын засварын материал	2,259,800.04	5,124,349.21
35470	Бусад хангамжийн материал	3,138,778,688.15	3,719,214,692.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	39,283,709,325.91	39,352,898,315.06
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	39,283,709,325.91	39,352,898,315.06
392	Биет хөрөнгө	38,426,058,438.43	38,488,644,672.92
39201	Барилга, байгууламж, орон сууц	22,400,798,473.31	23,257,685,466.49
39202	Хуримтлагдсан элэгдэл	-18,333,690.05	-434,702,286.72
39203	Авто-тээврийн хэрэгсэл	179,418,375.00	204,386,416.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-159,691,238.20	-170,243,632.22
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	38,672,276,864.23	42,194,824,741.34
39206	Хуримтлагдсан элэгдэл	-23,198,545,161.73	-27,320,099,850.18
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	699,542,344.92	989,182,718.29
39208	Хуримтлагдсан элэгдэл	-356,896,162.56	-421,987,715.36
39214	Бусад үндсэн хөрөнгө	284,216,791.71	284,216,791.71
39215	Хуримтлагдсан элэгдэл	-138,282,296.70	-158,433,139.93
39217	Ном	61,554,138.50	63,815,163.50

393	Биет бус хөрөнгө	857,650,887.48	864,253,642.14
39301	Програм хангамж	218,941,903.00	89,191,903.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-191,676,115.52	-55,323,360.86
39303	Бусад биет бус хөрөнгө	830,385,100.00	830,385,100.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	44,307,929,754.03	44,676,460,258.72
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	84,618,038.94	53,406,807.75
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	84,618,038.94	53,406,807.75
412	Богино хугацаат зээлийн өглөг	41,055,028.94	38,421,874.75
4121	Төгрөг	41,055,028.94	38,421,874.75
41211	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	41,055,028.94	38,421,874.75
413	Өглөг	43,563,010.00	14,984,933.00
4136	Бусад өглөг	43,563,010.00	14,984,933.00
41361	Байгууллагад төлөх өглөг	43,563,010.00	14,984,933.00
41363	Татварын өглөг	0.00	350,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	44,223,311,715.09	44,623,053,450.97
51	Засгийн газрын хувь оролцоо	44,223,311,715.09	44,623,053,450.97
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	21,376,629,291.33	21,376,629,291.33
512	Хуримтлагдсан үр дүн	13,438,933,990.62	13,831,830,226.50
51210	Өмнөх үеийн үр дүн	13,557,167,149.12	13,438,933,990.62
51220	Тайлант үеийн үр дүн	-118,233,158.50	392,896,235.88
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	9,407,748,433.14	9,414,593,933.14
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	44,307,929,754.03	44,676,460,258.72

